



Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид дэлхий нийтийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах энхийг сахиулах ариун үйлсэд үүрэг гүйцэтгээд эдүгээ 17 жил болжээ.

Энхийг сахиулах ажиллагаанд цэргээ илгээснээр Монгол Улсын нэр хүнд олон улсад оссоний зэрэгцээ, Монгол Улсын Засгийн газар, Зэвсэгт хүчний хөгжлийн санд багагви хоронгийг товлорүүлж эх орныхоо хөгжил дэвшил, Зэвсэгт хүчний шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд цэргийн багууд багагви хувь нэмрийг оруулжээ.

Үүнээс гадна ажиллагааны омнох сургалт бэлтгэл, ажиллагааны газар орны үүрэг гүйцэтгэлтээс хуримтлуулсан туршлага сургамж нь дараа дараагийн цэргийн багийг ажиллагааны газар оронд илгээх, эх орноо гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах бэлтгэлжилтийг хангах, үндэсний цэргийн урлагийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр болж байна.

Бид бүхэн ажиллагааны газар оронд ирэхээс омно, ирсний дараа омнох мотобуудлагын батальонуудын боловсруулж хэвлүүлсэн туршлага, сургамжтай танилцан ажиллагааны газар оронд шилжин байрлахад бэлтгэх арга хэмжээ, ээлж хвлээлцэх, үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай үнэ цэнэтэй, нарийн чухал мэдээллийг авсан юм. Ийм ч учраас оорийн батальоны үүрэг гүйцэтгэх үеийн онцлог, туршлага, сургамжийг багтаасан дурсамжийн номтой болохоор шийдвэрлэсэн юм.

Бидний үүрэг гүйцэтгэх 13 сарын хугацаанд ажиллагааны газар орны цагийн байдал харьцангуй тогтвортой, сорголдогч талуудын хооронд байгуулсан “Энхийн гэрээ”

хэлэлцээр хэрэгжиж эхэлснээр нутгийн иргэдийн сэтгэлд амар тайван амьдрах итгэл буцалж, эх орон, нутаг орноосоо дүрвэн гарсан олон мянган иргэд буцан ирсэн, газрын тосны хамтарсан вйлдвэрүүдийн вйл ажиллагаа сэргэсэн, Бентью хотын дотоодын дүрвэгсдийн хуаранд амьдрагч иргэдийн амьдралд хувьсал оорчлолт гарсан, нутаг орондоо эргэн ирэгсэдэд дэмжлэг үзүүлсэн онцлог бүхий жил байлаа.

Ийм ч учраас энэхүү номонд ажиллагааны газар орны цэрэг улс торийн цагийн байдал, түүний орнол, мотобуудлагын батальоны үндсэн болон хангалтын салбаруудын үүрэг гүйцэтгэлтийн онцлог, штабын толовлот, Монгол Улс, Зэвсэгт хүчний удирдлагаас цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг түүхтэй тусгасан бөгөөд ажиллагааны үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон удирдлагын баримт бичиг, мотобуудлагын батальонд тавигдах ерөнхий шаардлагын талаар олон мотобуудлагын батальоны туршлага сургамжаас уншиж болох юм.